*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 тоот тушаалын 7 дугаар хавсралт*

# ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ГАЗРЫН СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ, БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН ДАРГА А.АМАРСАЙХНЫ 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

## НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Эхний хагас жил | Сүүлийн хагас жил | | |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1.8.**<br>**Газар, байгаль, эдийн засаг, нийгмийн нөөц, чадавхад тулгуурлан газар ашиглалт, хамгаалалтын үр ашгийг дээшлүүлэх, газрыг иргэд болон эдийн засгийн хувьд үндэслэл сайтай, үр ашигтай, экосистемийн тэнцвэрт байдлыг хангасан газар зохион байгуулалтыг хөгжүүлж, газрын нөөцүүдийг оновчтой ашиглаж хэвшинэ.** | | | | | | | | |
| **1.1.1** | **Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах** | **Улсын төсөв 1200.0 сая** | **Батлагдсан улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө** | **Засгийн газрын 2018 оны 384 дүгээр тогтоолоор батлагдсан.** | **Төлөвлөгөөний төслийг боловсруулах, улсын хэмжээнд 21 аймаг, нийслэлээс төслийн хэлэлцүүлэг зохион байгуулж, төслийг Засгийн газарт өргөн барьж батлуулсан байна.** | | | |
| 1.1.1.1 | Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний 2024 оны | Үйл ажиллагаа | Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төсөл, танилцуулга, товч тайлан | Засгийн газрын 2018 оны 384 дугаар тогтоолоор улсын газар зохион байгуулалтын | Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг нийслэл, 21 аймаг, | | Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний 2024 оны хэрэгжилтийн тайланг холбогдох яам, агентлаг, 21 аймаг, нийслэлээс 2025 оны 01 дүгээр сарын 25-ны дотор хүлээн авч, нэгтгэж, нэгдсэн тайланг гаргасан. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжилтийг гаргаж, нэгтгэх | | | ерөнхий төлөвлөгөө батлагдсан. | 11 яам, 1 агентлаг, 3 чөлөөт бүсээс хүлээн авч нэгтгэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн байна. | | Мөн газрын даргын 2025 оны А/01 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт ажиллан, улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний 2024 оны хэрэгжилтийн тайлан, товч танилцуулга, холбогдох мэдээллийг гарган "Газрын нэгдмэл сангийн 2024 оны улсын нэгдсэн тайлан"-д тусгаж, Засгийн газрын 2025 оны 03 дугаар 19-ний хуралдаанд танилцуулсан. | |
| 1.1.1.2 | Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллаа-гаа | | Засгийн газрын 2018 оны 384 дүгээр тогтоолоор батлагдсан. | Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын хүрээнд Зөвлөх багтай гэрээ байгуулж, ажлын даалгавар болон шаардагдах зардлын тооцоог боловсруулсан байна. | Зөвлөх үйлчилгээнд хяналт тавих үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, ажлын даалгавар, зардлын тооцоог хянуулж батлуулсан байна. Төлөвлөгөө боловсруулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулах ажлыг зохион байгуулж, гүйцэтгэгч байгууллагатай хамтран ажилласан байна. | Газрын даргын 2025 оны А/42 дугаар тушаалаар "Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэх ажлын даалгавар" боловсруулах үүрэг бүхий салбар дундын ажлын хэсгийг байгуулж, ажлын даалгаврын төслийг боловсруулан Газар зохион байгуулалтын орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн 2025 оны 03 дугаар 28–ны өдрийн 1 дүгээр хурлаар, Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн хурлаар 2025 оны 03 дугаар 31–ний өдрийн 1 дүгээр хурлаар тус тус хэлэлцүүлж, газрын даргын дэргэдэх зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн хуралд танилцуулан дэмжигдсэн бөгөөд 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн АД/2025-43 дугаартайгаар батлуулсан. Тус газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 16-ний А/135 дугаар тушаалаар Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах Зөвлөх үйлчилгээг зарлах, зохион байгуулах үүрэг бүхий Үнэлгээний хороог байгуулсан. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 2025 оны 4 дүгээр сарын 18-ний өдөр ГЗБГЗЗЕГ/202501030006/01/01 дугаартайгаар Төрийн худалдан авах | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-д зарласан.<br><br>2025 оны 05 дугаар сарын 09-ний өдөр тендерийг нээхэд 1 ч оролцогч материал ирүүлээгүй байсан тул үнэлгээний хорооны шийдвэрээр тендерийг дахин 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдөр ГЗБГЗЗЕГ/20250103006/02/01 дугаартайгаар Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-ээр зарлаад байна. | |
| **Стратегийн төлөвлөгөөний зорилго 1.15. Салбарын хууль тогтоомжийг шинэчлэн боловсруулах, батлуулах** | | | | | | | | |
| **1.15.1** | **Хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийг боловсруулах, санал авах, олон нийтээр хэлэлцүүлэх, эрх бүхий байгууллагад өргөн барих, батлуулах ажлыг зохион байгуулах** | **Үйл ажилла-гаа** | **5 хуулийн үзэл баримтлалын төсөл** | **-** | **Газрын багц хуулийн төслийн үзэл баримтлал болон хуулийн төслийг эцэслэн боловсруулж, газрын багц хуулийн төслийг батлуулахад шаардлагатай ажлыг зохион байгуулсан байна.** | | | |
| 1.15.1.4 | Газар зохион байгуулалт, суурь судалгаа, мониторинг, газрын кадастрын болон бусад салбарын чиглэлээр боловсруулагдаж буй журам, заавар, | Үйл ажиллагаа | Санал өгсөн баримт бичгийн тоогоор | - | Хэлтсүүдийн шинээр боловсруулсан болон шинэчлэн боловсруулсан журам, заавар, аргачлалд санал өгч, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажилласан байна. | Хэлтсүүдийн шинээр боловсруулсан болон шинэчлэн боловсруулсан журам, заавар, аргачлалд санал өгч, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж | Кадастрын хэлтсээс боловсруулсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын төсөлд тухай бүр санал өгч хамтран ажилласан.<br>Төрийн захиргаа, удирдлагын газраас боловсруулсан ажлын төлөвлөгөөнүүдэд тухай бүр санал өгч ажилласан.<br>Газрын нэгдмэл сангийн 2025 оны улсын нэгдсэн тайлангийн товхимлын | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | аргачлалд санал өгөх, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах | | | | | ажилласан байна. | хэвлэлийн эхийг хянан засвар хийлгэхээр өгсөн.<br>Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх ажлын үнэлгээг шинэчлэх, аргачлал боловсруулах үүрэг бүхий салбар дундын ажлын хэсэгт орж ажиллаж, мэдээлэл цуглуулж, төслийг боловсруулах ажлын хэсгийн гишүүдтэй хамтран ажиллаж байна. | |
| 1.15.1.5 | Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийн биелэлт, хэрэгжилтийг тайлагнах чиглэлээр сургалт зохион байгуулах | Үйл ажиллагаа | 1 сургалт | | **Эхний хагас жилд:**<br>Ерөнхий газрын газар, хэлтсийн дарга нарыг хамруулан Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийн биелэлт, хэрэгжилтийг тайлагнах талаар сургалт зохион байгуулагдсан байна. | | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан Хяналт-шинжилгээ, үнэлгээ, байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам мөн Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийн биелэлт, хэрэгжилтийг тайлагнах, чиглэлээр байгууллагын албан хаагчдад сургалт зохион байгуулахаар Засгийн Газрын хяналт хэрэгжүүлэх газарт 2025 оны 1/1714 дугаар албан бичгийг хүргүүлсэн. | 70 |
| **Стратегийн төлөвлөгөөний зорилго 1.16.Салбарын бодлого, салбар хоорондын уялдаа холбоог хангах, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах** | | | | | | | | |
| **1.16.1** | **Салбарын болон бусад төрийн байгууллагуу-дын төлөвлөгөө, бодлогын баримт бичгүүдийн уялдааг хангах хурал, зөвлөлгөөн зохион байгуулах** | **Үйл ажилла-гаа** | **Зохион байгуулсан арга хэмжээний тоо** | **Газрын харилцаа эрдэм шинжилгээ-ний хурал жил бүр зохион байгуулагд-сан** | **Салбарын бодлогын баримт бичгүүд, төлөвлөгөөний уялдааг хангах зорилгоор бусад төрийн байгууллагууд, эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран зохион байгуулж үр дүнг нийтэлсэн байна.** | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.16.1.1 | Монгол Улсыг 2026-2031 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хөтөлбөрийн төсөлд оруулах саналыг боловсруулж, холбогдох газарт хүргүүлэх | Үйл ажиллагаа | төлөвлөгөөний төсөл | - | | Монгол Улсыг 2026-2031 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн төлөвлөгөөний төсөлд оруулах саналыг боловсруулж, хүргүүлсэн байна. | Хугацаа болоогүй (IV улиралд хийхээр төлөвлөгдсөн). | - |
| 1.16.1.2 | Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний төсөл боловсруулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлэх | Үйл ажиллагаа | Жилийн төлөвлөгөөний төсөл | Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө Монгол Улсын Их Хурлын 2024 оны 35 дугаар тогтоолоор батлагдсан. | Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний саналыг боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлсэн байна. | | Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т заасны дагуу Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний төслийн саналыг Санхүү, эдийн засгийн хэлтэстэй хамтран боловсруулж, салбарын өнөөгийн байдал, тоон үзүүлэлтүүдийг 2019-2024 оны байдлаар, мөн салбарын 2025-2026 болон 2026-2028 оны хөгжлийн төсөөлөл, хүрэх үр дүн, хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээ, салбарт тулгарч болзошгүй эрсдэлийн талаарх танилцуулгыг тус газрын 2025 оны 1/305 дугаар албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон Эдийн засаг, хөгжлийн яаманд тус тус хүргүүлсэн. | 100 |
| 1.16.1.3 | "Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын стратеги төлөвлөгөө" (2025-2028) боловсруулж, батлуулах | Үйл ажиллагаа | Байгууллагын 4 жилийн стратеги төлөвлөгөө | "Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын стратеги төлөвлөгөө" (2024-2028) батлагдсан. | "Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын стратеги төлөвлөгөө" (2025-2028) боловсруулж, батлуулсан байна. | Төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажлыг зохион байгуулан ажилласан байна. | Байгууллагын 2025-2028 оны стратеги төлөвлөгөөний төслийг газрын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн хүрээнд холбогдох хууль, тогтоомж, журмын дагуу боловсруулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн бөгөөд тухайн төлөвлөгөө нь 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргаар батлагдсан. Батлуулсан төлөвлөгөөг 21 аймгийн ГХБХБГ-т тус газрын 2025 оны 1/1566, нийслэлийн Газар зохион | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байгуулалтын албанд 2025 оны 1/1565 дугаар албан бичгээр тус тус хүргүүллээ. | |
| 1.16.1.4 | Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг гаргаж тайлагнах | Үйл ажиллагаа | Хөтөлбөрийн биелэлт | Монгол Улсын Их Хурлын тогтоолоор батлагдсан. | | Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг гаргаж, холбогдох газарт тайлагнасан байна. | Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг нэгтгэн 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр газрын даргад танилцуулсан. Засгийн газрын Хяналт-шинжилгээ үнэлгээний мэдээллийн цахим сан (unelgee.gov.mn)-д гүйцэтгэлийг тайлагнах хугацаа болоогүй. | - |
| 1.16.1.5 | Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг гаргаж, тайлагнах | Үйл ажиллагаа | Үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт | Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор | Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг гаргаж, холбогдох газарт тайлагнасан байна. | Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг гаргаж, холбогдох газарт тайлагнасан байна. | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 218 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжүүлэх 31 арга хэмжээний хэрэгжилтийг нэгтгэн Засгийн газрын Хяналт-шинжилгээ үнэлгээний мэдээллийн цахим сан (unelgee.gov.mn)-д гүйцэтгэлийг тайлагнахаар бэлтгэсэн. Талбар нээгдээгүй байна. | 100 |
| 1.16.1.6 | Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний биелэлтийг гаргаж тайлагнах | Үйл ажиллагаа | Төлөвлөгөөний биелэлт | Монгол Улсын Их Хурлын 2024 оны 35 дугаар тогтоолоор батлагдсан. | | Төлөвлөгөөний биелэлтийг гаргаж тайлагнасан байна. | Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн хэрэгжилтийг холбогдох нэгжүүдээс авч нэгтгэн 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр газрын даргад танилцуулсан. Засгийн газрын Хяналт-шинжилгээ үнэлгээний мэдээллийн цахим сан (unelgee.gov.mn)-д гүйцэтгэлийг тайлагнахаар бэлтгэсэн. Талбар нээгдээгүй байна. | 100 |
| 1.16.1.7 | Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурал болон Засгийн газрын тогтоол, шийдвэрүүдийн | Үйл ажиллагаа | Газрын харилцаатай холбоотой бүх тогтоол, шийдвэр | - | Тогтоол, шийдвэрүүдийн биелэлтийг эхний хагас жилийн байдлаар гаргаж, тайлагнасан байна. | Тогтоол, шийдвэрүүдийн биелэлтийг жилийн нцсийн байдлаар гаргаж, тайлагнасан байна. | Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа 2050” хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан 22 арга хэмжээний хэрэгжилтийг нэгтгэн газрын даргад 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр хүргүүлсэн. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | биелэлтийг гаргаж тайлагнах | | | | | | Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийн нэгдсэн тайлангийн төслийн агуулга, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн тоон мэдээллийн саналыг тус газрын 2025 оны 1/1892 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.<br>Засгийн газрын 2025 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан Цөлжилттэй тэмцэх тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын суурь конвенцын оролцогч Талуудын 17 дугаар Бага хурал (COP17)-ыг 2026 онд Монгол Улсад зохион байгуулах ажлын хэсгийн хурлын бэлтгэлд зориулан ерөнхий мэдээлэл болон байгууллагын оролцооны тухай танилцуулгыг бэлтгэн хүргүүлсэн. | |
| 1.16.1.8 | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар болон урсгал төсвөөр хийгдэж байгаа ажлуудад хяналт тавих | Үйл ажиллагаа | батлагдсан төсвийн хүрээнд | - | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар болон урсгал төсвөөр хийгдэж буй ажлуудын явцад хяналт тавьж, хэрэгжилтийг хангаж ажилласан байна. | Гэрээт ажлуудын эцсийн гүйцэтгэлийг хүлээн авах ажилд хяналт тавьж, хэрэгжилтийг хангаж ажилласан байна. | -Мэргэжлийн байгууллагын тусгай зөвшөөрөл бүхий "Эрхэт инноваци" ХХК-ийн гүйцэтгэсэн "Газрын кадастрын мэдээллийн сангийн архивын мэдээлэл болон нэгж талбарын өөрчлөлтийн түүхчилсэн лавлагааг хялбаршуулах, цахимжуулах ажил"-ын явцын тайлантай танилцаж, дүгнэлт гаргах ажилд оролцон ажиллав.<br>-2026 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлын зардлын тооцоо, холбогдох мэдээлийн хамт боловсруулж СЭЗХ-т хүргүүлсэн. | 70 |
| **Стратегийн төлөвлөгөөний зорилго 1.17.**<br>**Салбарын хүрээнд судалгаа шинжилгээний ажил эрхэлж, олон улсын дэвшилтэт техник, технологийг хэрэглээнд нэвтрүүлэх** | | | | | | | | |
| **1.17.1** | **Газар зохион байгуулалт, геодези, зураг зүй, орон зайн өгөгдлийн дэд бүтэц, газрын мониторингийн чиглэлээр судалгаа** | **Үйл ажиллага а** | **Судалгаа шинжилгээний баримт бичиг** | | **Холбогдох талуудтай хамтран газрын харилцааны судалгаа шинжилгээний ажлыг зохион байгуулж, судалгааны** | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | **шинжилгээний ажил эрхлэх** | | | | **материалыг байгуулагын албан хаагчид болон олон нийтэд хүргэсэн байна.** | | | |
| 1.17.1.1 | Газрын харилцааны чиглэлээр ашиглагдаж буй техник, технологийн судалгаа шинжилгээ хийх | Үйл ажиллагаа | Судалгааны гүйцэтгэл | 2024 онд хийгдсэн судалгааны ажлыг нэгтгэж дүгнэсэн. | Газрын харилцааны чиглэлээр техникийн судалгаа шинжилгээний ажил хийж, дүгнэлт гарган холбогдох хурлаар хэлэлцүүлсэн байна. | Холбогдох хурлаар хэлэлцүүлж гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж, биелэлтэд оролцсон байна. | Газрын харилцааны чиглэлээр олон улсын хэмжээнд сүүлийн үед ашиглагдаж байгаа техник, технологийн судалгааг интернэт, ашиглан орос, англи хэлээр хайлт хийн судалгаа хийж байна. Энэ ажлын хүрээнд “Газар зохион байгуулалтын салбарт томоохон өөрчлөлтүүдийг хийж буй техник, технологийн дэвшил” нийтлэлийг орчуулсан бөгөөд дараах технологиуд олон улсын хэмжээнд нийтлэг ашиглагдаж байна. Үүнд:<br>• Газар зүйн мэдээллийн систем<br>• Нисгэгчгүй нисэх төхөөрөмж<br>• Зайнаас тандан судалгаа ба хиймэл дагуулын зураг<br>• фермийн ухаалаг технологи<br>• дижитал зураглал, 3D загварчлал гэх мэт.<br>Мөн Казакстан улсын ХАА-н үндэсний их сургуулиас гаргасан “Үл хөдлөх хөрөнгийн кадастрт ашиглагдаж буй орчин үеийн технологи” сэдэвт өгүүллийг орос хэлнээс орчуулан судалсан.<br>НҮБ-ын Дэлхийн гео-орон зайн мэдээллийн менежментийн Ази, Номхон далайн бүсийн Гүйцэтгэх зөвлөлийн хурлын үеэр газрын удирдлага болон орон зайн мэдээллийн салбарын техник, технологийн шинэчлэлт, ололтын талаар илтгэл, танилцуулгууд хийгдсэн бөгөөд үүнээс БНХАУ, БНСУ, Япон Улс, Сингапур Улсуудын | 50 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | туршлага дээрээс үндэслэн орон зайн бодит өгөгдлийг шуурхайгаар цуглуулах, хиймэл оюун ухаан болон машин сургалтын аргуудыг ашиглан өгөдлийг боловсруулж тооцоолол хийх, яаралтай тайланг боловсруулах, үр дүнг шийдвэр гаргалт болон гамшгийн эсрэг үйл ажиллагаанд үр дүнтэй ашиглах талаарх судалгаа хийж байна. | |
| 1.17.1.2 | Газрын харилцааны салбарын хүний нөөцийн нэгдсэн судалгаа хийх, дүгнэлт гаргах | Үйл ажиллагаа | Судалгааны гүйцэтгэл | - | Газрын харилцааны салбарын хүний нөөцийн нэгдсэн судалгааг урт, богино хугацаагаар гарган холбогдох хурлаар хэлэлцүүлсэн байна. | | Газрын харилцааны салбарын хүний нөөцийн нэгдсэн судалгааг байгууллагын бүх албан хаагчид, аймаг, нийслэлийн газрын алба, газрын даамалууд, мэргэжилтэнүүд, Их дээд сургуулийн багш, төгсөгчид, мэргэжлийн байгууллага, Төрийн бус байгууллагын төлөөлөөс санал асуулгыг "google Forms"-д https://forms.gle/B3BrHfkBRWRgZHUm9 байршуулан 500-гаад судалгаанд оролцогчдоос саналыг авч нэгтгэж, товч тайлангийн хамт нэгжийн даргад танилцуулсан. | 80 |
| 1.17.1.3 | Газрын харилцааны чиглэлээр олон улсын туршлага, техник технологийн ололтыг судалж, хэрэглээнд нэвтрүүлэх саналыг боловсруулах | Үйл ажиллагаа | Олон улсын туршлага, саналын төсөл | 2024 онд газрын харилцааны чиглэлээр олон улсын туршлага, техник технологийн ололтыг судалж, удирдлагад танилцуулсан. | Газрын харилцааны чиглэлээр олон улсын туршлага, шинэ техник технологийн судалгааг боловсруулж, удирдлагад танилцуулсан байна. Газрын харилцааны чиглэлээр олон улсын туршлага, шинэ техник технологийн судалгааг боловсруулж, удирдлагад | | Үр ашигтай газар олголт, ашиглалт, дахин төлөвлөлтийн олон улсын судалгааг хийж танилцуулан, бусад нэгжүүдийн судалгаа, саналын мэдээллийг нэгтгэн хүлээлгэн өгсөн.<br>Эхний хагас жилд дараах чиглэлээр судалгааг хийж, судалгааг үндэслэн хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг сүүлийн хагас жилд боловсруулахаар төлөвлөн ажиллаж байна. Үүнд:<br>• газар зүйн мэдээллийн системийн программ хангамж<br>• мэдээллийн сангийн техник, технологи<br>• зайнаас тандан судалгааны аргууд<br>• газрын харилцааны салбарын институци. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | танилцуулсан байна. | | Газрын нөөцийн үр ашигтай хуваарилалтыг үнэлэх, төлөвлөх үйл явцыг хиймэл оюун ухааны тусламжтайгаар сайжруулах тухай саналыг боловсруулж байна. | |
| 1.17.1.4 | Газрын харилцааны чиглэлээр олон улсын болон гадаад, дотоодын байгууллагууд-тай хамтран хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн саналыг боловсруулах | Үйл ажиллагаа | Хамтран ажиллах санал | Өмнөх жилүүдэд гадаадын төрийн байгууллагууд-тай харилцаа тогтоож, хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан. | Газрын харилцааны чиглэлээр олон улсын болон гадаад дотоодын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн санал боловсруулж, удирдлагад танилцуулсан байна | Газрын харилцааны чиглэлээр олон улсын болон гадаад дотоодын байгууллагууд-тай хамтран хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн санал боловсруулж, холбогдох хурлаар хэлэлцүүлсэн байна. | НҮБ-ын Дэлхийн геодезийн шилдгүүдийн төвийн Дэлхийн геодезийн хангамжийн сүлжээг бэхжүүлэх тухай олон талт санамж бичигт гарын үсэг зурж, Монгол Улсыг төлөөлөн нэгдсэн бөгөөд тус санамж бичгийг Монгол хэл рүү орчуулан, 2025 оны 3 дугаар сарын 13-ны байдлаар шинэчлэгдсэн албан ёсны хуулбарын хамт ГХЯ-нд хүргүүлсэн.<br>ОХУ-ын улсын бүртгэл, кадастр, зураг зүйн алба (Росреестр)-тай байгуулах санамж бичгийн төслийг Монгол хэл рүү орчуулсан.<br>ЮНЕСКО-ын ивээл доор Исланд Улсад зохион байгуулагддаг GRO-LRT газар нөхөн сэргээлтийн олон улсын хөтөлбөрийн зохион байгуулагчтай хийсэн уулзалт, хэлэлцээрийн хүрээнд богино хугацааны газрын нөхөн сэргээлтийн сургалтад хамрагдах сонирхолтой албан хаагчдын судалгааг салбарын хэмжээнд 197 албан хаагчаас авч, судалгааны тайланг бэлтгэн Исланд Улсын зохион байгуулагчдад хүргүүлсэн.<br>БНХАУ-ын Геодези, төлөвлөлтийн хүрээлэн болон Сингапур Улсын Газрын алба нартай хамтран ажиллах талаар хэлэлцээрүүдийг зохион байгуулж, санамж бичгийн төслүүдийг хүргүүлсэн. | 100 |
| 1.17.1.5 | Газар зохион байгуулалт, хот байгуулалт, газрын мониторинг, газрын | Үйл ажиллагаа | Судалгааны ажлын тайлангийн тоогоор | - | Газар зохион байгуулалт, хот байгуулалтын чиглэлээр судалгаа, шинжилгээний | Газрын мониторинг, газрын кадастрын чиглэлээр судалгаа | -ОХУ-ын Газрын тухай хуулийн агуулгыг орчуулан тус хуулийн талаарх танилцуулгыг бэлдэн байгууллагын удирдлагад танилцуулсан.<br>-Улсын газар зохион байгуулалтын | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | кадастрын чиглэлээр судалгаа шинжилгээний ажил хийх | | | | ажил хийж холбогдох хурлаар хэлэлцүүлсэн байна. | шинжилгээний ажил хийж холбогдох хурлаар хэлэлцүүлсэн байна. | ерөнхий төлөвлөгөөний ажлын даалгаврыг боловсруулах ажлын хүрээнд 5 улсын урт хугацааны үндэсний орон зайн төлөвлөлтийн баримт бичгийг Монгол Улстай харьцуулсан судалгаа шинжилгээний ажлыг хийж, тусгах боломжтой саналын дүгнэлтийг боловсруулсан. Хот, суурингийн эдэлбэр газрыг тогтоох тухай олон улсад баримталдаг зарчмуудын хураангуй судалгаа хийсэн. | |

## ГУРАВ. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Эхний хагас жил | Сүүлийн хагас жил | | |
| **Стратегийн төлөвлөгөөний зорилго 3.9.Салбарын бодлого, салбар хоорондын уялдаа холбоог хангах, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах** | | | | | | | | |
| **3.9.1** | **Салбарын болон бусад төрийн байгууллагуудын төлөвлөгөө, бодлогын баримт бичгүүдийн уялдааг хангах хурал, зөвлөгөөн зохион байгуулах** | **Үйл ажилла-гаа** | **Зохион байгуулсан арга хэмжээний тоо** | **Газрын харилцаа эрдэм шинжилгээний хурал жил бүр зохион байгуулагдсан.** | **Салбарын бодлогын баримт бичгүүд, төлөвлөгөөний уялдааг хангах зорилгоор бусад төрийн байгууллагууд, эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран зохион байгуулж үр дүнг нийтэлсэн байна.** | | | |
| 3.9.1.1 | Орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн хуралдаан зохион байгуулах, | Үйл ажиллагаа | Хуралдааны тоо<br>Газар зохион байгуулалтын орон тооны бус | 2024 онд Газар зохион байгуулалтын орон тооны бус мэргэжлийн | Орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн хурлыг зохион байгуулж, хурлаас гарсан шийдвэрийг | Орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн хурлыг зохион байгуулж, хурлаас гарсан | Газар зохион байгуулалтын орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн хурлаар 2025 онд хэлэлцүүлэх асуудлыг Газрын даргын 2025 оны А/49 дүгээр тушаалаар батлуулав. 2025 онд тухайн зөвлөл нь нийт 6 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хурлаас өгсөн үүрэг даалгаврыг албажуулах, тайлагнах | | мэргэжлийн зөвлөл | зөвлөл 6 удаа хуралдсан. | албажуулж, тайлагнасан байна. | шийдвэрийг албажуулж, тайлагнасан байна. | удаа хуралдаж, нийт 17 асуудлыг хэлэлцэхээр төлөвлөгөө батлагдсан. Мөн хурал зохион байгуулахад шаардагдах зардлын тооцоог гарган тухайн тушаалын хавсралтаар батлуулав.<br>Мөн тус зөвлөлийн 2025 оны анхдугаар хурлыг 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулж, Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын даалгаврыг төслийг хэлэлцүүлэв.<br>2025 оны 05 дугаар сарын 28-ны өдөр тус зөвлөлийн 2 дугаар хурлыг зохион байгуулж, 3 асуудлыг хэлэлцүүлэв. | |
| 3.9.1.2 | Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн хурлыг зохион байгуулах, хурлаас өгсөн үүрэг даалгаврыг албажуулах, тайлагнах | Үйл ажиллагаа | Хуралдсан тоо | 2024 онд Шинжлэх ухаан, технологийн зөвлөл 1 удаа хуралдсан. | Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн хурлыг зохион байгуулж, хурлаас гарсан шийдвэрийг албажуулж, тайлагнасан байна. | Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн хурлыг зохион байгуулж, хурлаас гарсан шийдвэрийг албажуулж, тайлагнасан байна. | Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн хурлаар 2025 онд хэлэлцүүлэх асуудлыг Газрын даргын 2025 оны А/61 дүгээр тушаалаар батлуулав. 2025 онд тус зөвлөл нь нийт 5 удаа хуралдаж 15 асуудлыг хэлэлцэхээр төлөвлөгөө батлагдсан. Мөн хурал зохион байгуулахад шаардагдах зардлын тооцоог гарган тухайн тушаалын хавсралтаар батлуулсан.<br>Мөн тус зөвлөлийн 2025 оны анхдугаар хурлыг 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр зохион байгуулж, 2 асуудал хэлэлцүүлэв. | 100 |
| 3.9.1.3 | Газрын харилцааны салбарын ажилтны өдрийг тохиолдуулан оюутны эрдэм шинжилгээний бага хурлыг холбогдох сургуультай хамтран зохион байгуулах | Үйл ажиллагаа | Хурлын тоо | 2024 онд оюутны эрдэм шинжилгээний бага хурлыг МУИС-тай хамтран зохион байгуулсан. | Оюутны эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулагдсан байна. | | **Газрын харилцааны ажилтны өдрийг тохиолдуулан жил бүр уламжлал** болгон зохион байгуулагддаг “Ж.Наранцацралт багшийн нэрэмжит газрын харилцааны салбарын оюутны эрдэм шинжилгээний хурал-2025”-ыг МУИС-ийн I байрны Эрдмийн танхимд 2025 оны 05 дугаар 06-ны өдөр МУИС-тай хамтран зохион байгууллаа.<br>Тус эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулах, мөн 3-р байрын шагналд шаардлагатай зардал гаргах | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тухай агентлагийн даргын 2025 оны А/137 дугаар тушаалыг батлуулав.<br>Тухайн хуралд МУИС, ШУТИС, ХААИС, ҮТИС-ийн оюутнуудын ирүүлсэн 15 судалгаа, илтгэлийг шалгаруулан хэлэлцүүлж, дүнг гаргаснаар:<br>• 1-р байр: Ү.Энхзаяа /МУИС-ийн Газарзүйн тэнхимийн ГЗБ-ын IV түвшний оюутан/ - "Үерийн эрсдэлийн таамаглалын зураглалыг үерийн гамшгийн үеийн судалгаатай харьцуулсан шинжилгээ";<br>• 2-р байр: Г.Бат /ХААИС-ийн АЭС-ийн Газрын менежментийн тэнхимийн ГЗБ-ийн IV түвшний оюутан/ – "Янгир ямааны амьдрах орчныг Habitat model ашиглан загварчлах";<br>• 3-р байр: Б.Аззаяа, Д.Алтанхишиг /МУИС-ийн Газарзүйн тэнхимийн БОЗТС-ын IV түвшний оюутан/ – "Газарзүйн мэдээллийн системд суурилсан 20 минутын хот ба хүртээмжтэй байдлын судалгаа";<br>• Тусгай байр: Б.Эрдэнэжаргал, А.Хулан /МУИС-ийн Газарзүйн тэнхимийн БОЗТС-ын III түвшний оюутан/ – "Хангайн нурууны Баян-Өндөр уулын ойн талбайн өөрчлөлт" сэдэвт илтгэлүүдээр тус тус шалгарсан байна. | |

## ДӨРӨВ. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Эхний хагас жил | Сүүлийн хагас жил | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.1 | Удирдлагаас болон хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх, тайлагнах | Үйл ажиллагаа | Үүрэг даалгаврын тоо | Жил бүр хийгддэг. | | Өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлж, тухай бүр тайлагнасан байна. | Газрын даргын 2025 оны А/39 дүгээр тушаалаар ахлах мэргэжилтэн Б.Туул Өмнөговь аймгийн 4, Дундговь аймгийн 5 суманд очиж ажиллан сумын төрийн байгууллагын үйл ажиллагааны үнэлгээ бодит нөхцөл байдалд нийцэж буй эсэхэд хяналт шалгалт хийж тайланг хүргүүлсэн.<br>Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагын эзэмшил, ашиглалтад байгаа газруудын судалгааг Газрын кадастрын мэдээллийн сангийн 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн мэдээллээс түүвэрлэн гаргаж, газрын даргад танилцуулсан. | 100 |
| 4.1.2 | Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж, тайланг тушаалд заасан хугацаанд холбогдох мэргэжилтэнд хүргүүлэх | Үйл ажиллагаа | Тушаалд заасан хугацаа | Жил бүр хийгддэг. | | Ажлын хэсэгт ажиллаж, хэрэгжилтийг тухай бүр тайлагнасан байна. | 1.Газрын даргын 2025 оны А/01 дугаар тушаалаар байгуулагдсан ГНС-ийн тайлан гаргах “Ажлын хэсэг”-т Ахлах мэргэжилтэн Р. Отгончимэг, мэргэжилтэн А.Мишээл нар орж ажиллан, УГЗБЕТ-ний 2024 оны хэрэгжилтийн тайлан, товч танилцуулга, холбогдох мэдээлэл, байгууллагын 2024 оны гадаад хамтын ажиллагааны тайланг бэлтгэж Ажлын хэсгийн нарийн бичигт хүргүүлэн ажиллаж, холбогдох хурлуудаар хэлэлцүүлсэн.<br>2.Газрын даргын 2025 оны А/42 дугаар тушаалаар байгуулагдсан Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэх “Ажлын даалгавар боловсруулах үүрэг бүхий салбар дундын “Ажлын хэсэг”-т Ахлах мэргэжилтэн Р. Отгончимэг, мэргэжилтэн А. Мишээл нар орж ажиллан Ажлын даалгаврын төслийг боловсруулсан, мөн ажлын хэсгийн гишүүдээс өгсөн саналыг нэгтгэж, ажлын даалгаврын төсөлд тухай бүр тусгаж, холбогдох хурлаар хэлэлцүүлсэн.<br>3. Төрийн албаны зөвлөлийн даргын 02 дугаар “ Ажлын хэсэг байгуулах тухай” тушаалаар ахлах мэргэжилтэн Б.Туул Өмнөговь. Дундговь аймгийн сумдын Төрийн байгууллагын үйл ажиллагаанд Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлж буй байдал, хүний нөөцийн зохицуулалтын хэрэгжилттэй танилцан хяналт шалгалт хийж хэрэгжилтийг ажлын хэсэгт тайлагнаж ажилласан. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 4.Газрын даргын 2025 оны А/170 дугаар тушаалаар байгуулагдсан Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх ажлын үнэлгээг шинэлчэн боловсруулах үүрэг бүхий салбар дундын "Ажлын хэсэг"-т орж ажиллаж байна | |
| 4.1.3 | Тогтоол шийдвэрийн биелэлт гаргах | Үйл ажиллагаа | Тогтоол, шийдвэрийн тоо | Жил бүр хийгддэг. | | Холбогдох тогтоол шийдвэрийн биелэлтийг цаг хугацаанд тайлагнасан байна. | Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоол Алсын хараа 2050 хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан 22 арга хэмжээний биелэлт<br>- Монгол Улсын Их Хурлын 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 35 дугаар тогтоол Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний биелэлт<br>-Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 218 дугаар тогтоол Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжүүлэх 31 арга хэмжээний биелэлт<br>-Монгол Улсын Их Хурлын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 23 дугаар тогтоол Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хөтөлбөрийн биелэлтийг тус тус гаргасан. | 100 |
| 4.1.4 | Хугацаатай албан бичиг, өргөдөл гомдол шийдвэрлэх, хяналт тавьж ажиллах | Үйл ажиллагаа | Шийдвэрлэсэн албан бичиг, өргөдөл, гомдлын тоо | Жил бүр хийгддэг. | | Нэгжид ирсэн хугацаатай албан бичиг, өргөдөл гомдлыг заасан хугацаанд нь шийдвэрлэсэн байна. | Тайлант хугацаанд тухайн газарт нийт 52 албан бичиг ирснээс хариутай 7 хариугүй 45 байна. Хариутай бичгүүдийг хугацаанд нь шийдвэрлэсэн<br>- Тус газраас 2025 оны 1 дүгээр улиралд нийтдээ 25 албан бичгийг боловсруулж, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хүргүүлсэн байна.<br>- Тайлант хугацаанд 2026 оны төлөвлөгөөний төслийн саналыг боловсруулж, 2026-2028 оны хөгжлийн төсөөлөл, хүрэх үр дүн, хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээ, салбарт тулгарч болзошгүй эрсдэл талаарх танилцуулгыг тус газрын даргын 2025 оны 1/305 дугаар албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт болон Эдийн засаг, хөгжлийн яаманд тус тус хүргүүлсэн.<br>- УГЗБЕТ-ний ажлын хэсэгт орох нэр игрүүлэх тухай 2025 оны 1/330 дугаартай албан бичгийг холбогдох яам, холбоод, их дээд | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сургууль, төрийн бус байгууллагуудад тус тус хүргүүлсэн.<br>- Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан "Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийн явцын тайлангийн төслийн агуулга, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн тоон мэдээллийн саналыг газрын даргын 2025 оны 1/1892 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. | |
| 4.1.5 | Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивын баримт бүрдүүлэх, хавтаслах, байгууллагын архивт хүлээлгэн өгөх | Үйл ажиллагаа | Архивт хүлээлгэн өгсөн баримтын тоо | Жил бүр хийгддэг. | | Нэгжийн урьд онд хийсэн ажлын баримт бичгийг тайлант оны эхний улиралд багтаан байгууллагын архивт хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулсан байна. | Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу холбогдох байгууллагуудаас ирүүлсэн хариутай албан бичгүүдийн хариуг хүргүүлж ирсэн бичгийг шийдвэрлэн архивд хүлээлгэн өгсөн. | 100 |

## ТАВ. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Д/д | Боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвараа сайжруулах арга хэмжээ | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|
| "ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ, САЛБАРЫН ХУУЛЬ, ДАГАЛДАН ГАРСАН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ЭЗЭМШИХ, ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛЭХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД: | | | | |
| 1 | Богино, дунд хугацааны мэргэшүүлэх сургалтанд хамрагдах | Сургалтанд хамрагдсан байна. | Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдал хангах сургалтад. "Төрийн болон албаны нууцын тухай хууль, журам түүнийг хэрэгжүүлэхэд анхаарах асуудлууд" сургалтанд хамрагдсан. | 100 |

*Төлөвлөгөөг үнэлсэн:* **Төсвийн шууд захирагч**

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ,
ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА .......................................................... /А.ЭНХМАНЛАЙ/
*(албан тушаал)* *(гарын үсэг)*

*(огноо)*

*Тэмдэг* ............................

*Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:* **Нэгжийн дарга**

......................................... ......................................... /................................./
*(албан тушаал)* *(гарын үсэг)*

*(огноо)*

..............................

*Тайлагнасан:* **Нэгжийн дарга**

ГАЗРЫН СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ, БОДЛОГО
ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН ДАРГА ............................................................ /А.АМАРСАЙХАН/
*(албан тушаал)* *(гарын үсэг)*

2025.08.09
*(огноо)*